



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.3, 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай" Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Хилийн боомтын дэд бүтэц" төслийн хүрээнд хийгдэх ажлын бэлтгэл хангах зайлшгүй шаардлагыг харгалзан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Дорноговь аймгийн Замын-Үүд Хилийн мэргэжлийн хяналтын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 325,103,308.80 (гурван зуун хорин таван сая нэг зуун гурван мянга гурван зуун найман төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ, 41,899,623.70 (дөчин нэгэн сая найман зуун ерэн есөн мянга зургаан зуун хорин гурван төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг буулгаж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Үл хөдлөх хөрөнгийг буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албаны зориулалтаас өөр хэлбэрээр ашиглахгүй байх;

2.4. Үл хөдлөх хөрөнгийг буулгаж, ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж, худалдан борлуулах;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000047





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 01 дүгээр сарын 22 -ны өдрийн  
28... дугаар тогтоолын хавсралт

**Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Замын-Үүд Хилийн мэргэжлийн хяналтын албаны  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт**

| Д/д      | Хөрөнгийн нэр                                              | Ашиглал<br>тад<br>орсон<br>огноо | Хэм<br>жих<br>нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ<br>/төгрөг/                                                                                                   | Балансын үнэ<br>/төгрөг/                                                                                                     | Хуримтлагдсан<br>элэгдэл /төгрөг/                                                                                             | Үлдэгдэл үнэ<br>/төгрөг/                                                                                                          |
|----------|------------------------------------------------------------|----------------------------------|--------------------|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1        | Бүртгэл, хяналтын байр<br>/гарах талын/                    | 2013.01.31                       | ш                  | 1   | 14,200,230.00                                                                                                                | 14,200,230.00                                                                                                                | 1,832,126.00                                                                                                                  | 12,368,104.00                                                                                                                     |
| 2        | Бүртгэл, хяналтын байр<br>/орох талын/                     | 2013.01.31                       | ш                  | 1   | 14,200,231.00                                                                                                                | 14,200,231.00                                                                                                                | 1,832,126.00                                                                                                                  | 12,368,105.00                                                                                                                     |
| 3        | Цацрагийн цахилгаан нөөц<br>үүсгүүрийн байр<br>/сендвичен/ | 2008.01.01                       | ш                  | 1   | 11,495,648.80                                                                                                                | 11,495,648.80                                                                                                                | 11,495,648.80                                                                                                                 | 0.00                                                                                                                              |
| 4        | Мэргэжлийн хяналтын<br>давхар хяналтын байр                | 2008.10.01                       | ш                  | 1   | 3,000,000.00                                                                                                                 | 3,000,000.00                                                                                                                 | 3,000,000.00                                                                                                                  | 0.00                                                                                                                              |
| 5        | Мэргэжлийн хяналтын<br>давхар хяналтын байр                | 2017.11.25                       | ш                  | 1   | 10,000,000.00                                                                                                                | 10,000,000.00                                                                                                                | 594,195.00                                                                                                                    | 9,405,805.00                                                                                                                      |
| 6        | Ариутгалын байр                                            | 2017.10.25                       | ш                  | 1   | 93,400,000.00                                                                                                                | 93,400,000.00                                                                                                                | 1,751,250.00                                                                                                                  | 91,648,750.00                                                                                                                     |
| 7        | Цэвэр бохир усны шугам                                     | 2017.10.26                       | ш                  | 1   | 30,000,000.00                                                                                                                | 30,000,000.00                                                                                                                | 952,380.80                                                                                                                    | 29,047,619.20                                                                                                                     |
| 8        | Ариутгалын байрны авто<br>зам                              | 2012.12.31                       | ш                  | 1   | 148,807,199.00                                                                                                               | 148,807,199.00                                                                                                               | 20,441,897.10                                                                                                                 | 128,365,301.90                                                                                                                    |
| Нийт дүн |                                                            |                                  |                    |     | 325,103,308.80<br>(гурван зуун<br>хорин таван сая<br>нэг зуун гурван<br>мянга гурван<br>зуун найман<br>төгрөг наян<br>мөнгө) | 325,103,308.80<br>(гурван зуун<br>хорин таван сая<br>нэг зуун гурван<br>мянга гурван<br>зуун найман<br>төгрөг наян<br>мөнгө) | 41,899,623.70<br>(дөчин нэгэн сая<br>найман зуун ерэн<br>есөн мянга<br>зургаан зуун<br>хорин гурван<br>төгрөг далан<br>мөнгө) | 283,203,685.10<br>(хоёр зуун наян<br>гурван сая хоёр<br>зуун гурван<br>мянга зургаан<br>зуун наян таван<br>төгрөг арван<br>мөнгө) |